

АГУУЛГА

1. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

1.1 Аудитын зорилго

1.2 Аудитын цар хүрээ

2. ТАНИЛЦУУЛГА

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Илэрсэн асуудлууд, Дүгнэлт

3.2. Зөвлөмж

1. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

1.1 Аудитын зорилго

Амгалан дулааны станц ТӨХК-н ажил үйлчилгээ, бараа материал худалдан авах үйл ажиллагаанд хийх дотоод аудит нь төрийн болон компанийн хөрөнгөөр ажил , үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах захилагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарыг хараат бус, бодитой байдлаар үнэлж, холбогдох дүгнэлт, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах замаар ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, зарцуулалтын үр ашиг, үр нөлөөг сайжруулах зорилготой.

1.2 Аудитын цар хүрээ

- Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө байгууллагын бодит хэрэгцээнд (хэрэгцээг үнэлсэн) тулгуурласан бөгөөд үүнд зорилтыг биелүүлэхэд шаардагдах чанар, тоо хэмжээ, цаг хугацааг харгалзсан эсэх
- Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан ажил үйлчилгээ болон худалдан авах үйл явц нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах
- Гүйцэтгэгч бараа, ажил үйлчилгээг заасан хугацаанд нь тоо, чанарын зохих шаардлагын дагуу нийлүүлэх үүргээ биелүүлсэн эсэх
- Ажил үйлчилгээ худалдан авалтын тендерийн материалтай танилцах, үнэлэлт өгөх
- Ажил ,үйлчилгээ худалдан авалтын гэрээний биелэлтэнд үнэлэлт дүгнэлт хийх, бараа материалын чанарыг шалгах
- Худалдан авалтын баримт , тендерийн бичиг баримтанд үзлэг шалгалт хийх, тэдгээрийн баримт бүрдүүлэлт үнэлэлт өгөх
- Бараа материалын үнэлгээ, худалдан авалтын үнийг гэрээ хэлцэл, бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх зэрэг баримттай тулган шалгах
- Бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэлийг өглөгийн данс болон мөнгөн зарлагын баримтанд тулган шалгах

2. ТАНИЛЦУУЛГА,

“Амгалан дулааны станц” ТӨХК нь 2022 оны Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын төлөвлөгөөнд нийт 14.506.277,4 мян/төгрөгийн ажил үйлчилгээ болон бараа худалдан авах төлөвлөгөөг Амгалан дулааны станцын ТӨХК-ний ТҮЗ-ын 2022 оны 01 дугаар сарын 12-ний өдрийн /01 тоот хурлын тэмдэглэлээр дэмжигдсэн байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар 1,986.827.2 мян/ төгрөгийн өртөгтэй, 13 нэр төрлийн ажил ,үйлчилгээ бараа худалдан авах тендер, Харьцуулалтын аргаар 1.180.812.6 мян/ төгрөгийн 27 нэр төрлийн ажил, үйлчилгээ бараа худалдан авах тендер, Шууд худалдан авах аргаар 326.616.6 мян/төгрөгийн 20 нэр төрлийн ажил , үйлчилгээ, бараа сэлбэг материал худалдан авах ажил , ХТШ –р нэг төрлийн нүүрсний тендерт 10.989.172.0 мян/төгрөгийн , ГШБ –р 22.849,0 мян / төгрөгөөр төлөвлөсөн байна.

А. Хангамжийн хэлтэс нь 2022 оны 10 сарын байдлаар нээлттэй тендер шалгаруулалт худалдан авалтын төлөвлөгөөгөөр 1,986.827.2 мян/төгрөгийн өртөгтэй 13 нэр төрлийн нээлттэй тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан байна. Үүнд:

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн дотоод аудитын ажлын тайлан

№	Тухай жилд худалдан авах барааны, ажил үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Худалдан авах ажиллаг аанд мөрдөх журам	Батлагдсан төсөвт өртөг /мян. төг/	Гэрээний дүн /мян.төг/	Тендерт шалгарсан компанийн нэр	Тайлбар
	Нээлттэй тендер шалгаруулалт					
1	Үутат шүүлтүүр № 1,2,3-н уут нийлүүлэх	НТШ	101.360,0	99.851,5	Скайблю фортун ХХК	2022.7-21-нд 35.955,0₮-р нэмэлт гэрээг байгуулсан.
2	Шатахуун нийлүүлэх	НТШ	325.186,2	325.186,2	МТ Петролиум ХХК	Гэрээний дагуу явагдаж байгаа
3	Өрлөг дулаалгын материал /Шавар зуургч, шингэн цавуу, корунд, пластик, шавар/	НТШ	130.750,0	130.710,8	Дээд тив ХХК	Хугацаа хэтэрсэн
4	Зуух №2 их засвар	НТШ	280.000,0	280.000,0	Хүчин титэм ХХК	НТШ-р 2 удаа зарлаж, шууд гэрээ байгуулсан. Нэмэлтээр 2022.07-21нд 39.450,0₮-н гэрээг дахин хийсэн.
5	Зуух №3 их засвар	НТШ	263.000,0	263000,0	Хүчин титэм ХХК	НТШ-р 2 удаа зарлаж, шууд гэрээ байгуулсан. Нэмэлтээр 2022.07-21нд 42.000,0₮-н гэрээг дахин хийсэн.
6	G250 маркын компрессорын сэлбэг	НТШ	139.585,0	128.229,6	Галт цамхаг ХХК	Гэрээ

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн дотоод аудитын ажлын тайлан

						дүгнэх хугацаа хоцорсон.
7	Сүлжээний усны ДУ700-н бөмбөлгөн хаалт нийлүүлэх	НТШ	150.000,0	148.995,0	И ЖИ ӨҮ ХХК	Гэрээ дүгнэх хугацаа хоцорсон.
8	Техникийн давс	НТШ	85.000,0	63.294,0	Ноён өдөр уул ХХК	Хугацаанд а хийгдээгүй, нийлүүлэлт дутуу нэмэлтээр 2022.10-03 ил Ирмүүн бармат ХХК-иас 18.600,0₮-р 20тн давс авсан
9	Дотоод хэрэгцээний хүчин чадал нэмэгдүүлэхэд шаардлагатай сэлбэг материал	НТШ	100.000,0			ТШ- зарлагадсан
10	Хоолой /оёдолгүй/	НТШ	74.637,0	74.231,1	Галт цамхаг ХХК	Гэрээт хугацаа хоцорсон, Барааг хүлээн авах комиссийн дүгнэлт байхгүй.
11	ТУСП сэлбэг хэрэгсэл	НТШ	161.800,0	149.900,0	Эрчим эрхт элч ХХК	Гэрээ дүгнэх хугацаа хоцорсон
12	ДХХА сэлбэг хэрэгсэл	НТШ	86.315,0	81.717,5	Торго магнаг ХХК	Гэрээ дүгнэх хугацаа хоцорсон
13	Комьютер түүний дагалдах хэрэгсэл	НТШ	89.194,0	82.588,0	Сүүхүнги ХХК	Гэрээ дүгнэх хугацаа хоцорсон
	Нийт дүн		1.986.827,2	1.963.708,7		

Нийт 13 нээлттэй тендерээс 12 тендерийн шалгаруулалт дуусаж, 1 тендер шалгаруулах цахим тендер хийгдээгүй байна.

НТШ-н нийт 1.986.827,2 мян/төгрөг төлөвлөснөөс 1.963.708,7 мян/төгрөгийн гүйцэтгэлтэй, “Дотоод хэрэгцээний хүчин чадал нэмэгдүүлэхэд шаардлагатай сэлбэг материал шалгаруулах” НТШ тендер хийгдээгүй байна. ~

Б. Харьцуулалтын аргаар худалдан авалтын тендер :

Хангамжийн хэлтэс нь 2022 оны эхний 10 сарын байдлаар Харьцуулалтын аргаар худалдан авалтын төлөвлөгөөнд 27 тендерийг цахимаар зарлаж, нийт 27 тендер шалгаруулж, гэрээ нийт

батлагдсан төсөвт өртөг нь 1.180.812,6 мян/төг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1.114.198,8 мян/төгрөгийн худалдан авах тендерийн үйл ажиллагааг явуулсан байна.

В. Шууд худалдан авах аргаар худалдан авалт:

2022 оны 10 сарын байдлаар төлөвлөгөөгөөр 326.616,6 мян/төгрөгийн 20 нэр төрлийн худалдан авалтын бараа , сэлбэг материал авах тендер зарлаж, 265.767,5 0 мян/төгрөгийн нийт 21 Аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн байна.

Шалгалтын хугацаанд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Амгалан дулааны станцын 2022 оны аж ахуйн нэгж байгууллагатай хийгдсэн гэрээ болон Хангамжийн хэлтсийн ажилтнаас өгсөн 29 ширхэг үдэж хавтасласан тендерийн баримт, дискэнд, тулгуурлаж аудитын шалгалтыг хийлээ.

Шалгалтаар нийт 74 тендер зарлаж НТШ 13 , ХА-н аргаар 27 тендер , ШХА 21 бараа материалийг нийлүүлж, гэрээ дүгнэж , бараа болон ажил үйлчилгээг хүлээлгэн өгсөн байна.

Дээрхи 2022 оны ажил, үйлчилгээ бараа худалдан авах ажиллагаа ерөнхийдөө хуулийн хүрээнд явагдсан байгаа боловч **шалгалтын явцад дараах зөрчил дутагдлууд гарч байна.**
Үүнд:

1. Уутат шүүлтүүр №1,2,3 уут нийлүүлэх гэрээг Скайблю фортуун ХХК –тай 2022 оны 05 дугаар сарын 15-наас 45 хоногийн дотор барааг нийлүүлэхээс, 45 хоног хэтэрсэн хугацааг сунгасан байна.
2. Өрлөг дулаалгын материал нийлүүлэх гэрээг Дээд тив ХХК-тай 2022 оны 05дугаар сарын 17-наас 30 хоногийн дотор нийлүүлэх гэрээ хийгдсэн боловч, хугацаандаа нийлүүлэлт хийгдээгүй, бараа хүлээн авсан комиссын дүгнэлт байхгүй.
3. Техникийн давс нийлүүлэх гэрээг Ноён өндөр уул ХХК 2022 оны 03 дүгээр сарын 04-ний өдрийн №21 тоот гэрээгээр 30 хоногийн дотор 100тн техникийн давс нийлүүлэх байсан боловч гэрээг дүгнээгүй, хугацаандаа нийлүүлээгүй , 23тн давсиг дутуу нийлүүлсэн байна. Давсиг орлогод авахдаа 4 удаагийн орлогын бичилтийг хэмжигдхүүн болон үнийн дүнг буруу илэрхийлж, санхүүгийн баримтанд зөрчилтэй оруулсан байна.

10000кг-10кг, 1кг давсны үнийг /575төг,40 мөнгө/-г 575400төгрөгөөр оруулж бичсэн.

Гэрээний үүргийн биелэлтэнд хариуцлага тооцож, дуусгаагүй мөртлөө Ирмүүн бармат ХХК-наас 20тн давсиг 18.600,0 мян/төгрөгөөр шууд худалдан авалтаар хийгдсэн, 1кг давсиг 930 төгрөгөөр авсан нь хэмнэлтийн хуулийг зөрчиж үнэ давс авсан. Шууд худалдан авах болсон шалтгаан, техникийн комиссын дүгнэлт, шийдвэрийг гаргаагүй байна.

4. G250 маркын компрессорын сэлбэг нийлүүлэх гэрээг Галт цамхаг ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 02-ноос 45 хоногт нийлүүлэх гэрээ хийгдсэн боловч, гэрээг дүгнээгүй хугацаа хоцорсон , барааг хүлээн авах комиссын дүгнэлт байхгүй.

5. Сүлжээний усны ДУ700-н бөмбөлгөн хаалт нийлүүлэх гэрээг И ЖИ ӨҮ ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 18 –наас 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, гэрээг 3 сарын дараа буюу 2022 оны 08 дугаар сарын 02 нд гэрээг дүгнэсэн, барааг шалгаж хүлээн авсан комиссын дүгнэлт гараагүй .

6. Хоолой /оёдолгүй/ нийлүүлэх гэрээг Галт цамхаг ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 10-наас 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр гэрээг дүгнэсэн гэрээний хугацааг сунгасан боловч, дахин 21 хоног хэтрүүлсэн. Хугацаа хэтрүүлсэн алданги 1,5 сая/төгрөгийг тооцсон байна.

7. ТУСП-н сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гэрээг Эрчим эрхт элч ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 17-наас 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, хугацаандаа нийлүүлээгүй, 2022 оны 05дугаар сарын 02 нд гэрээ дүгнэсэн актыг үйлдсэн боловч, барааг хүлээн авах комиссын дүгнэлт гаргаагүй, хугацаа хэтэрсэн.

8. ДХХА-н сэлбэг нийлүүлэх гэрээг Торго магнаг ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 14-нээс 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, гэрээний хугацаа хэтэрсэн, барааг хүлээн авах комиссын дүгнэлт гаргаагүй байна.

9. Комьютер болон дагалдах хэрэгсэл худалдан авах гэрээг 2022 оны 05 дугаар сарын 09- ны өдөр Сүүхүнгий ХХК-тай 14 хоногийн хугацаатай гэрээ байгуулсан боловч, гэрээг хугацаандаа дүгнээгүй, хугацаа хоцорч нийлүүлсэн, чанарын шаардлага хангагүй, техникийн тодорхойлтонд АНУ-н барааг авах байтал, Хятад улсын бараа нийлүүлсэн.

10. Ажлын хувцас нийлүүлэх гэрээг Дөргэнэ бүрд ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 17-ноос 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, гэрээний хугацаа хэтэрсэн, гэрээ дүгнээгүй, барааг хүлээн авах комисс дүгнэлт гаргаж, хүлээн аваагүйгээс ажлын хувцас хэмжээнд хүрэхгүй, багадах, томдох, зарим ажилчдад таарах хувцас ирээгүй учраас ажлын хувцасгүй биеэн тамирын хувцас, ноосон цамцтай ажиллаж байгаа нь Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.2.2-д заасан заалтуудыг ноцтой зөрчиж байна.

11. Ажлын гутал нийлүүлэх гэрээг Баян цагаан нуур ХХК –тай 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, барааг хүлээн авах комиссын дүгнэлт байхгүй, гутлын размер хэмжээнээс том, өөрөө хэлбэл гутал дээр байгаа размерийн хэмжээ 40 байхаас 41,42 хэмжээтэй байгаа нь гутал томдох, хөл холгох, зэрэг ажиллах нөхцлийг хангахгүй

байгаа Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.2.2-д заасан заалтуудыг ноцтой зөрчиж байна.

12. Цахилгааны дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээг Торго магнаг ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 17-ноос 30 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, хугацаандаа нийлүүлээгүй, барааг хүлээн авах комиссын дүгнэлт гаргаагүйгээс, 200ш /лед дөрвөлжин/ гэрлээс 43 ш гэрэл нь эвдрэл гэмтэлтэй гарсан. Энэ гологдлыг Хангамжийн хэлтэс болон Санхүүгийн хэлтэсээс нийлүүлэгч байгууллагатай холбогдож, гэмтэлтэй ирсэн барааг солиулах, төлбөр тооцоо нийлсэн актуудыг хийгээгүй байна.

10. Зуух №2, №3-н Их засварын ажил гүйцэтгэх тендерийг цахим тендерээр 2 удаа зарласан боловч, оролцогч байхгүй шалтгаанаар Хүчит титэм ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна. Ажил гүйцэтгэх хугацаа хэтэрсэн, гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах ажлын комиссын дүгнэлтгүй, гэрээг дүгнэсэн ажлын акт болон ажлын гүйцэтгэлийн фото зураг байхгүй, дахин нэмэлтээр 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдөр №83, №84 тоот гэрээг нэмэлтээр тус тус хийж, гэрээний дүнг 81.450.000,00 төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Нэмэлт гэрээг хийх болсон шалтгаан, үндэслэлээ Ерөнхий инженерээр ахласан техникийн комиссын дүгнэлт гаргасан шийдвэр байхгүй,

Хүчит титэм ХХК –тай байгуулсан 2022 оны 5дугаар сарын 17-ны өдрийн № 62, № 63 тоот гэрээний 3.2-дахь заалтад / Гэрээт ажлын үнийн дүнгийн 50 хувь болох 140.000.000,00 /Нэг зуун дөчин сая/ төгрөгийг, 131.500.000,00 / Нэг зуун гучин нэгэн сая/ төгрөгийг гэрээ баталгаажсанаас хойш ажлын 5 /тав/ хоногийн дотор гүйцэтгэгчийн Хас банкны 5003247323-тоотод шилжүүлнэ.

Гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийн 50 хувийг ажлын тайлан, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 30 /гуч/ хоногийн дотор гүйцэтгэгчийн Хас банкны 5003247323 тоот дансанд шилжүүлнэ / гэж гэрээнд заасан бөгөөд нийт санхүүжилт болох 271.500,0 мян/төгрөгийг, 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдөр Голомт банкны данснаас санхүүжүүлсэн.

Гүйцэтгэгч тал гэрээт ажлыг хүлээлгэн өгөөгүй , гэрээг дүгнээгүй байхад 2022 оны 7 сарын 29-ний өдөр 142.523.258 төгрөгийг касснаас анхан шатны ямарч баримт бүрдүүлээгүй , мөнгийг бэлэнээр гаргасан, мөнгө хүлээн авсан хүний гарын үсэг зурж, баталгаажсан тамга тэмдэгтэй баримт байхгүй, Зуух №2-н их засварын ажлын гүйцэтгэлийн №1-н төсөвт өртгийн товчоо гэсэн өртгийн төсөвийг Ерөнхий инженерээр Э.Мөнхжаргалаар батлуулаагүй төсвийг баримт болгосон байгаа нь, мөн Монкоул петро майнинг ХХК-д касснаас 2 удаа 2022 оны 7 дугаар сард /Арван

таван сая/ 15.000.000төгрөг, 8 дугаар сард /Нэг зуун гурван сая дөрвөн зуун таван мянга найман зуун жаран дөрвөн төгрөг тавин тавин мөнгө/ 103.405.864.55 төгрөгийг тус тус бэлэн өгсөн нь

Амгалан дулааны станц ТӨХК-н Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/12 дугаар тушаал “Кассын үйл ажиллагааны журмын 2.3, 2.6, 2.7, 2.8, 2.20, 2.22 заалтуудыг ,

Ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн

- 20.1.2 дахь заалтанд заасны дагуу хууль тогтоомжид харшилсан шийдвэр хийхээс татгалзах , -20.1.4 дэхь заалтад хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар , эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил , гүйлгээг бүртгэхгүй байх,
- 20.2.4 дэхь заалтад НББ хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах,
- 20.2.5 дахь заалтад дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, зэрэг дээрхи заалтуудыг тус тус зөрчсөн байна.

13. Галын дохиололын системийг шинэчлэн засварлах ажил гүйцэтгэх, галаас хамгаалах сэлбэг хэрэгсэл нийлүүлэх гэрээг Стандарт нетворк ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 15-наас 2022 оны 08 дугаар сарын 18 хүртэлхи хугацаатай гэрээг хийгдсэн боловч, ажил гүйцэтгэлийг шалгаж хүлээн авсан комиссын дүгнэлт байхгүй, хугацаа хоцорсон.

14. Ахуйн байрны засварын ажил гүйцэтгэх гэрээг Цэгц мөрөн ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 18-наас 45 хоногийн хугацаатай гэрээ хийгдсэн боловч, хугацаа хоцорсон, ажил хүлээн авах комиссын дүгнэлт байхгүй, тухайн байгууллагын ажил гүйцэтгэсэн ажлын тайлан, ажлын гүйцэтгэлийн явцыг харуулсан фото зураг байхгүй, гэрээг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр дүгнэсэн боловч, гэрээ дүгнэсэн акт шаардлага хангахгүй. 2022 оны 06 дугаар сарын 27-нд нэмэлт гэрээг байгуулж, 5,9 сая/төгрөгөөр нэмэгдсэн байна.

15. Бараа материал нийлүүлэгч байгуулагууд нь гэрээний хавсралтын дагуу бараа материалын жагсаалтаар барааг хүлээлцэж, хүлээн авах комисс барааны тоо% ширхэг болон чанар, бараа материалын гарал үүслийн бичиг, баталгаа, ашиглалтын заавар байгаа эсэх зэргийг шалгаж, барааг авахыг зөвшөөрсөн комиссын дүгнэлт гаргаж, гишүүдийн гарын үсэг зурж баталгаажсан жагсаалт байхгүй, зөвхөн зарлагын баримтаар нярав орлогод авч, НХМаягт БМ-1 маягтаар “Бараа материал хүлээн авалтын орлогын баримтанд комиссын гишүүд гарын үсэг зурж, хүлээлцэж байгаа дутагдал гарч байна. 10 дүгээр сарын 18,19,20 -ны гүйлгээг Бараа материал хариуцсан нягтлан бодогчийн алдаа илэрхийлсэн баримтыг хавсаргав.

16. Хангамжийн хэлтсийн ажилтнуудаас тендерт шалгаруулах явц болон тендерт ирүүлсэн материал болон худалдан авалтын баримтыг хугацаанд бүрэн гаргаж өгөөгүй, аудитын шалгалтыг гүйцэт хийлгэх, боломж бүрдүүлж өгөхгүй зэрэг дутагдлууд гарч байна. Үүнд: АДС-ТӨХК-н албан хэрэгцээнд ашиглаж байгаа Сайт-н Нийтийн фолтер дээр Дотоод аудитор гэсэн шейр дээр Тендерийн материал , Гэрээ , Үнэлгээний хорооны тэмдэглэл гэсэн шейр дээр материал дутуу тавьсан. / Ш. Гантулга, Г.Баярчимэг /

17. Хангамжийн хэлтсийн дарга Г.Эрдэнэбилэг нь ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлын байрны үндсэн чиг үүрэгт:

- Худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТ-н хууль, холбогдон гарсан дүрэм, журмын дагуу зохион байгуулах,
- Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтын журам, тендерийн урилга, тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаархи мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг тогтоон хугацаанд нь мэдээлэх,
- Хариуцсан ажилтнуудаа мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангаж, ажлын гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавьж, зөрчилгүй ажиллах,
- Тендер, худалдах худалдан авах ажиллагаатай холбоотой бүх төрлийн гэрээ болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулах гэрээний төслийг боловсруулж, хянуулан албажуулах, гэрээний биелэлтэнд хяналт тавьж гүйцэтгэлийг хугацаанд нь дүгнэх,

Ажлын байранд хийгдэх үйл ажиллагаанд:

- худалдан авах ажиллагаатай холбоотой тушаал төлөвлөх, хянуулах, албажуулах,
- Үнэлгээний хорооны хуралдааныг зарлан мэдээлэх, зохион байгуулах, худалдан авах ажиллагаанд баримтлах хууль тогтоомжийн талаарх мэдээллээр гишүүдийг хангах, тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт, материалыг бүрдүүлж, хавтаст хэрэг хөтлөх, баримтжуулж, хадгалах, хурлын тэмдэглэл хөтөлж албажуулахад хяналт тавьж, биелэлтийг хангах
- Санхүү эдийн засгийн хэлтэстэй тухай бүр тооцоо нийлүүлж ажиллах зэрэг ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг удаа дараа гүйцэт биелүүлээгүй.
- Амгалан дулааны станц ТӨХК-н Гүйцэтгэх захирлын А/95 тоот тушаалын хавсралтаар гэрээ дүгнэх комиссын гишүүнд Хангамжийн хэлтсийн дарга Г.Эрдэнэбилэг байгаа бөгөөд би гэрээ дүгнэхгүй гэх байхгүй гэх шалтгаан хэлж, уг тушаалыг зөрчиж, үүрэгт ажлаа бүрэн хариуцаж хийгээгүй байна.

- Өмнөх онуудын аудитын шалгалтаар 2020 онд 13 зөрчилд 11 зөвлөмж, 2021 онд 7 зөрчилд 10 зөвлөмжийг хүргүүлсэн боловч, ажил сайжрахгүй, өмнөх жилүүдээс зөрчил дутагдал нэмэгдэж байна.
- Хангамжийн хэлтсийн дарга Г. Эрдэнэбилэгт ажил сайжруулах талаар 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн № 05 тоот албан шаардлага, 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн №2 тоот аудитын мэдэгдлээр удаа дараа аудитын төлөвлөгөөт шалгалтанд худалдан авалтын болон тендерийн баримт гарч өгөөгүй, шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангахгүй байна гэж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх болон Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б. Ган-Очир нарт ажлын хариуцлагын тооцож, арга хэмжээ авч өгнө үү гэсэн албан мэдэгдлийг өгч байсан. Мөн 2022 оны 03дугаар сарын 10-ны өдрийн №01тоот албан шаардлагыг тус тус хүргүүлсэн болно. Г. Эрдэнэбилэгийн ажлын байранд тавигдах шаардлагад “Мэргэжил” Эрчим хүч, санхүү, эдийн засгийн мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байх, “Туршлага” Эрчим хүчний салбарт болон худалдан авах ажиллагаагаар 5-аас доошгүй жил ажилласан байх гэсэн шаардлагыг хангахгүй байна.

18. Дээрхи Зуух №2. №3-ны их засварыг хийх болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг худалдан авахад Ерөнхий инженерээр ахлуулсан техникийн комиссыг хуралдаж, хурлын протоколь болон гишүүдийн санал, дүгнэлтийг нэгтгэн, техникийн комиссын дүгнэлт гарган байгууллагын удирдлагад танилцуулж, албажсан техникийн комиссын дүгнэлт байхгүй байна.

19. Амгалан дулааны станц ТӨХК-ний Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн A/95 тоот тушаалын хавсралтаар үйлдвэрлэлийн холбогдолтой тендерийн гэрээ дүгнэх комиссыг Ерөнхий инженерээр ахлуулсан комисс, үйлдвэрлэлийн бус тендерийн материалыг Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий няглан бодогчоор ахлуулсан комиссууд нь 2022 оны худалдан авалт болон тендерт шалгарсан хуулийн этгээдтэй хийсэн гэрээний үүргийн биелэлт, гэрээг дүгнэсэн актыг чанарын болон ажлын баримт болох хэмжээнд хийж, удирдлагад танилцуулаагүй. Техникийн комиссын дүгнэлт, акт нь ажлын баримтын шаардлага хангахгүй.

20. Ерөнхий нягтлан бодогч Θ. Удвал нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэг хариуцлагын хүрээнд гэрээ дүгнэх, ирсэн бараанд шалгалт хийхгүй, тооцоо нийлж, акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг ноцтойгоор зөрчиж, их хэмжээний бэлэн мөнгийг баримтгүй, харилцагч байгууллагын хүлээн авсан баримтгүй олгосон бөгөөд кассын баримтуудыг 7,8,9 саруудын баримтыг бүрдүүлж, архивын нэгж болоогүй, өөрийн удирдлаганд байгаа ажилчдын санхүүгийн ажлын баримтанд бүртгэлээр болон бодит байдалд хяналт тавиагүй зэрэг дутагдлууд гарсан.

Дээрхи зөрчлүүд нь компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дараахь байдлаар эрсдлийг үүсгэж байна. Үүнд:

- Гэрээг хугацаандаа дүгнэж хэвшихгүй байгаа, гэрээний хариуцлагыг сулруулах эрсдлийг бий болгож байгаагаас гадна гэрээний үүргийн биелэлт хангалтгүй , гэрээний үүргийн хэрэгжилтэнд тавьж байгаа хяналт сул байгаа нь компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх , компанийн гэрээгээр гүйцэтгүүлж буй ажлын үнэ цэнэ алдагдах, хөрөнгийн үр ашиг буурах, хууль зөрчигдөх эрсдлүүдийг бий болгож байна.
- Тендерийн үйл ажиллагаа зохион байгуулж байгаа үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь хурлын явц болон шалгаруулалтын явцын хуралдааны тэмдэглэлд гишүүдийн санал, дүгнэлтийг найруулга, зөв бичих дүрэмд нийцсэн, энгийн , тодорхой, хоёрдмол утгагүй, утга санааг зөв тодорхой бөгөөд оновчтой тэмдэглэл хийхгүйгээс үнэлгээний хорооны хуралдааны тэмдэглэл шаардлага хангахгүй байна.
- Давсыг орлогод авахдаа 4 удаагийн орлогын бичилтээр хэмжигдхүүн болон үнийн дүнг буруу илэрхийлж, санхүүгийн баримтанд зөрчилтэй оруулсан байна. 10000кг-10кг, 1кг давсны үнийг /575төг,40 мөнгө/-г 575400төгрөгөөр оруулж бичсэн нь УСНББОУС-н 5.1.4 заалтыг, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13.6-д заасан заалтыг зөрчиж, хэмжигдхүүний нэгж, үнийг буруу илэрхийлснээр бүртгэлд тавих хяналт байхгүй, тн, кг-н зөрүү дээр барааг дутаах,шамшигдуулах, алга болох эрсдлийг /нөхцлийг/ бий болгож байна.
- Бараа материал болон ажил гүйцэтгэх тендерийг хүлээн авах комисс нь ажлаа хийхгүй, комиссын дүгнэлт гаргахгүй, баримтыг нөхөж хийж байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, засварын ажлын гүйцэтгэл чанаргүйжих, чанарын баталгаагүй, шаардлага хангасан бараа сэлбгийг хүлээн авснаар, тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл гаргах нөхцлийг бий болгох эрсдэлтэй байна.
- Хүчит титэм ХХК-нд нэмэлт гэрээг байгуулсан, техникийн комиссын зохион байгуулаагүй, комиссын дүгнэлт шийдвэр байхгүй, 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Касснаас бэлэн анхан шатны баримт болох мөнгө хүссэн өргөдөл, кассын зарлагын баримт хүлээн авсан, хүний гарын үсэг болон Хүчит титэм ХХК-ний мөнгө хүлээн авсан орлогын баримтгүй мөнгө гаргасан нь ажлын гүйцэтгэл, ажлын комисс ажлаа дүгнээгүй , ажлыг шалгаж хүлээн аваагүй байхад их хэмжээний бэлэн мөнгө өгсөн нь аливаа нэг эрсдлийг үүсгэж, мөнгө гамшигдах нөхцлийг бий болгосон байна.
- Тендерт шалгарсан компаниудын ажлын гүйцэтгэлд хяналт тавих , гаднаас оруулж байгаа бараа материал , болон багаж хэрэгсэлд хяналтгүйгээс болж бараа материал, багаж хэрэгсэл алдагдах эрсдэл бий болох нөхцөл бүрдэж байна.

Дээрхи зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмж

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, ажил, үйлчилгээ , бараа худалдан авахдаа Гүйцэтгэх захирын тушаалаар батлагдсан комисс нь тогтоосон хугацаанд ажлын гүйцэтгэлд болон бараа материалыг чанарын өндөр түвшинд, ажлын акт үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулсны үндсэн дээр нягтлан бодох бүртгэлийн дагуу бүртгэн, анхан шатны баримтыг бүрдүүлж ,хүлээн авч, тооцоо нийлүүлж, үлдэгдлийн баталгааг баталгаажуулах,
2. Тендер шалгарсан компаниудын ажил гүйцэтгэх, бараа, сэлбэг, материал нийлүүлэх гэрээнд, Захиалагчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах нэр заагдсан “Ажилтан” нь тухайн гэрээний ажлын гүйцэтгэл болон бараа материалын чанарт хяналт тавьж, хугацаанд нь хийж гүйцэтгүүлэх, алданги тооцож ажиллах шаардлагатай байна,
3. Дээрхι алдаатай бүртгэсэн шалтгааныг тодруулж, НББОУС болон НББ-н хуулийн 15.1-д заасны дагуу алдааг засаж, залруулга хийх, Ерөнхий нягтлан бодогч ажлын хэсэг гаргаж тооллого хийх, анхан шатны баримтыг шалгах, алдаа гарсан нягтлан бодогч , няравт хариуцлага тооцох, байгууллагын удирдлага болон дотоод аудиторт тайлбар өгөх,
4. Ерөнхий нягтлан бодогч нь бэлэн мөнгө гаргасан шалтгаан тайлбарыг албан бичгээр хариу өгөх, баримтгүй өгсөн 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн касснаас 142.523.258 төгрөг, болон Монкоул петор майнинг ХХК-д нүүрсний төлбөрт төлсөн 15.000.000 төгрөг, 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 103.405.864.55 төгрөгийн анхан шатны баримтыг бүрдүүлж шалгуулах, бараа, сэлбэг материал болон ажил гүйцэтгэх гэрээг ажлын комисс дүгнэж, хүлээн авсан нөхцөлд бэлэн бусаар төлбөр тооцоог хийж, тооцоо нийлсэн актыг үйлдэж байх,
5. Их хэмжээний бэлэн мөнгийг касснаас гаргахгүй байх, ДЭХ борлуулсны төлбөрийг харилцах данс хийх
6. Ерөнхий нягтлан бодогч болон тооцоо буруу хийсэн нягтлан бодогч, нярав нарт холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах талаар Амгалан дулааны станцын ТӨХК-ний Гүйцэтгэх захиралд санал хүргүүлэх
7. Үнэлгээний хорооны хуралдааны тэмдэглэлийг Монгол хэлний зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу ЗГ-н 2020 оны 246 –р тогтоолын хавсралт “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.4.1 –дэх заалт, 3.3 дахь заалтын дагуу албан бичиг хэрэг хөтлөх шаардлагатай байна.
8. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг Төрийн болон орон нутгин өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7, 47.8 дахь хэсэгт заасны дагуу хөтлөх, хурлын тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтөлж байх.
9. Хангамжийн хэлтсийн дарга Г. Эрдэнэбилэг нь худалдан авалтын тендерийн үйл ажиллагааг хугацаанд ТБОНӨХБАҮХАТХ-н дагуу зөв зохион байгуулж ажиллах , хангамжийн ажилчдын ээлжийн амралт, ажлын цаг ашиглалт, ажил сайжруулах талаар ажил зохион байгуулах.
10. Шалгалтын хугацаанд тендерийн баримт бичиг материалыг хугацаанд нь гаргаж өгөөгүй , гэрээний дүгнэсэн байдалд хангалтгүй ажилласан Хэлтсийн дарга болон ажилчдад хариуцлага тооцох талаар Гүйцэтгэх захирал М.Мөнхөө , Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б. Ган-Очирт АДС-ТӨХК-ний 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/95 тушаалын дагуу арга хэмжээ авах саналыг хүргүүлж байна.
11. Амгалан дулааны станц ТӨХК-н 2022 оны бараа , ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу Худалдан авалтын цахим тендерийг хугацаанд хуулийн дагуу хийж гүйцэтгэх, худалдан авалтын гүйцэтгэлийг хуулийн дагуу эцсийн байдлаар үдэж ,

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн дотоод аудитын ажлын тайлан

архивын нэгж болгох, бичгийг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны дотор бэлэн болгож шалгуулахыг Хангамжийн хэлтсийн дарга Г. Эрдэнэбилэгт үүрэг болгож байна

12. Гэрээний үүргийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, түүнд тавьж буй хяналтыг сулруулсан, үнэлгээний хорооны дарга, гишүүд болон комиссын дарга, гишүүд гэрээт ажлыг хүлээн авах ажиллагааг хангалтгүй гүйцэтгэсэн албан тушаалтуудад хариуцлага тооцдог болгохыг Гүйцэтгэх захиралд санал хүргүүлж байна.
13. Хангамжийн хэлтсийн албан хаагчдыг худалдан авалтын ажлын үеүдэд сүл зогсолтонд хамрагдахгүй, ажиллуулах талаар холбогдох удирдлагуудад саналыг хүргүүлж байна.

Дээрхи зөрчлүүдийг арилгах талаар Дотоод аудиторын өгсөн зөвлөмжийн дагуу засаж ажиллахыг Санхүү, эдийн засгийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Θ.Удвал, Хангамжийн хэлтсийн дарга Эрдэнэбилэг, хангамжийн ажилтнуудад шаардаж байна. Зөвлөмжийн хариуг 2022 оны 11 дүгээр сарын 10 нд Дотоод аудиторт албан бичгээр гаргаж өгөхийг мэдэгдье.

Тайлан бичсэн:
ДОТООД АУДИТОР



Б. БЯМБАСҮРЭН

Танилцсан:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М. МОНХӨӨ

Хүлээн авсан:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Э. МОНХЖАРГАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Θ. УДВАЛ

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Г. ЭРДЭНЭБИЛЭГ

2022. 11.02